



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 07

Ч.Амгалан

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 64.4, 71.3, 71.4, 76.1.2, 76.1.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 25–ны өдрийн 10.00 цагт “Багануур Илч” ХХК-ийн байрны 2 давхар, 103 тоот хурлын танхимд хуралдуулсугай.

2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй:

2.1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2.2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2.3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;

2.4. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;

2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

3.Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл даргалахаар шийдвэрлэсүгэй.

4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг нэгдүгээр хавсралт ёсоор баталж, 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хоёрдугаар хавсралт ёсоор баталж, хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх, хурлын зарыг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин сурталчлахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралт ёсоор, Хэлэлцэх асуудалтай холбогдох танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралт ёсоор, Хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг тавдугаар хавсралт ёсоор, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал авах хуудасны загварыг зургаадугаар хавсралт ёсоор, Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтын хуудсыг долоодугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

6. Хурлын зарыг хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдэд болон зохих журмын дагуу 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор нийтэд мэдээллэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**7.1. Хурал даргалагч**

С.Наранцогт /Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал/

**7.2. Хурал зохион байгуулах комиссын дарга**

Д.Даваадаш /Багануур ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал /

**7.3. Хурал зохион байгуулах комиссын гишүүд**

-Б.Одгэрэл /Багануур ХК-ийн хуулийн зөвлөх/

-У.Батсуурь /Багануур Илч ХХК-ийн Гүйцэтгэх захирал/

-Г.Соёлмаа /Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын менежер/

-С.Одончимэг /Хэвлэл мэдээллийн ажилтан/

-Ч.Сайнзаяа /Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын туслах/

-А.Ганболор /Багануур ХК-ийн ажилтан/

**7.4. Хурал зохион байгуулах тооллогын комиссын дарга**

Б.Хажидмаа /Дотоод хяналт шалгалтын албаны дарга/

**7.5. Тооллогын комиссын гишүүд**

-Б.Наранцэцэг / Дотоод хяналт шалгалтын албаны мэргэжилтэн/

-М.Дондогдулам / Дотоод хяналт шалгалтын албаны мэргэжилтэн/

8. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17.00 цагаар тасалбар болгосугай.

10. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ПОНДОГМАА



“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 03 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт



**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ**

2024.03.15

Улаанбаатар хот

Компанийн нэр:	Багануур ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр хэсэг
Хурал хуралдах өдөр цаг:	2024 оны 04 дүгээр сарын 25 –ны өдрийн 10.00 цагт
Хурал хуралдах газар:	Улаанбаатар хот
Хурлын төрөл:	Ээлжит хурал
Хурал зарлагч:	Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр
Хурал даргалагчын нэр:	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт
Тооллогын комиссын дага, гишүүдийн нэр:	Б.Хажидмаа, Б.Наранцэцэг, М.Дондогдулам
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт, бичгийн хуудасны тоо	..... ширхэг .....хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /...../

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 04 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт.



## “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

2024.03.15

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00 цагт “Багануур” ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
4. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүлээн авах өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17.00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн “Багануур-Илч” ХХК, харьяа брокер, дилерийн компанид ирж танилцан хуралд идэвхтэй оролцоно уу.

### Хурал хуралдуулах газрын хаяг:

“Багануур” ХК-ийн охин компани “Багануур Илч” ХХК-ийн 2 давхарт 103 тоот хурлын танхимд /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 23-1 тоот/

### Лавлах утас:

“Багануур Илч” ХХК, утас 7015-7719

Хурал зохион байгуулах комисс: 9904-4373, 9902-8967

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**



“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 3 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт



**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

2024.03.15

Улаанбаатар хот

№	Хурлын дэг	Хугацаа
1.	Хурлын ирц бүртгэх	09.00-10.00
2.	Хурлын ирц мэдээллэх /Зохион байгуулах комисс/	5 минут
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг танилцуулах	5 минут
4.	Хурлын дарга хурлын үйл ажиллагааг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5.	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулах	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут
6.	Хурал оролцогсдын асуулт, хариулт	Хүн бүр 3 минут
7.	Хуралд оролцогсдын санал	Хүн бүр 3 минут
8.	Завсарлага	20 минут
9.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
10.	Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах	Асуудал тус бүрээр 15 хүртэл минут
11.	Хурлын ажиллагааг хаах	5 минут

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 07 дугаар  
тогтоолын 4 дүгээр хавсралт



**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ  
БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

2024.03.15

Улаанбаатар хот

1. “Багануур” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
2. “Багануур” ХК-ийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд
4. Холбогдох бусад материал

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 2 дугаар  
тогтоолын 5 дугаар хавсралт



**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР  
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар .....

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар.....

Санал өгөх хувьцааны тоо.....

Бүртгэсэн /брокер, дилерийн компани/

Брокерийн компанийн нэр.....

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00 цагт “Багануур Илч” ХХК-ийн 2 давхарт 103 тоот хурлын танхимд хуралдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1	Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;			
2	Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;			
3	Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;			
4	Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;			

Брокерийн ..... /...../

Хувьцаа эзэмшигчийн..... /...../



“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 2 дугаар  
тогтоолын 6 дугаар хавсралт



**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛААР ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ  
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....  
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар .....  
Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар.....  
Санал өгөх хувьцааны тоо..... Кумулятит саналын тоо.....  
Бүртгэсэн /брокер, дилерийн компани/  
Брокерийн компанийн нэр.....

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00 цагт “Багануур” ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдана.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн овог, нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
	Ердийн гишүүн	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
	Хараат бус гишүүн	
1		
2		
3		
4		

Брокерийн ..... /...../  
Хувьцаа эзэмшигчийн..... /...../



“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2024 оны 7 дугаар  
тогтоолын 7 дугаар хавсралт



**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

№	Зүйл	Тайлбар
1	Компанийн нэр:	
2	Хаяг, утас:	
3	ТУЗ-ийн хурал хийсэн огноо:	
4	Хурал зарлагчийн мэдээлэл	
5	Хороонд ирүүлсэн огноо: /хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор/	
6	Олон нийтэд зарлах огноо	
7	Эхний зарласнаас хойш 15 хоногт дахин зарласан эсэх	
8	Бүртгэлийн өдөр /нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр/	
9	Хэлэлцэх асуудал	
10	Саналын хуудасны загвар	
11	Саналын хуудас хүлээн авах өдөр	
12	Хурлын комиссын гишүүдийн нэрс	
13	Хурал хуралдуулах огноо /шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн өмнө/	
14	Хурал хуралдуулах газар байршил, хаяг Хурал хуралдуулах огноо, цаг	..... .....
15	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн нэр: Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн гарын үсэг Хурлын мэдэгдэл хянасан огноо	..... ..... .....